



**МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ,
БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ ТҮҮВЭР
СУДАЛГАА – 2009 ОН**

МБГС, Судалгааны хэлтэс

2009 он

†Энэхүү судалгааны ажилд дурьдагдсан үзэл баримтлалууд нь зөвхөн судлаачдын хувийн байр суурийг илэрхийлэх бөгөөд тэдний ажилдаг байгууллагын албан ёсны байр суурь байх албагүй

**МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ,
БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ ТҮҮВЭР
СУДАЛГАА – 2009 ОН**

1. Оршил

Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар Монгол Улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, банк санхүүгийн үйл ажиллагааны талаар 2009 оны 9 дүгээр сард олон нийтийн дунд зургаа дахь жилдээ санал асуулга явуулж, үр дүнг өмнөх онуудтай харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Энэ асуулгад Улаанбаатар хотын бүх дүүргүүд болон Говьсүмбэр аймгаас бусад аймгуудыг хамруулсан бөгөөд нийт 6571 иргэд оролцжээ. Үүнээс 18.3 хувь нь Улаанбаатар хотын оршин суугчид байна. Судалгаанд оролцсон иргэдийн 59 хувь нь эмэгтэй, 60 орчим хувь нь 26-45, 53.2 хувь нь дээд боловсролтой, 56 хувь нь хувийн хэвшилд ажилладаг. Санал асуулгад тусгагдсан 53 асуултыг агуулгаар нь ангилан 9 дэд бүлэг болгож, асуулт бүрээр дэлгэрэнгүй тайлбар, дүгнэлт өгөв.


1. Эдийн засгийн ерөнхий төлөв
2. Нийгмийн тулгамдсан асуудлууд
3. Санхүү эдийн засгийн хямрал
4. Татвар
5. Банк санхүүгийн салбар
6. Хадгаламж, хуримтлал
7. Зээл
8. Бичил санхүү
9. Жижиг дунд үйлдвэрлэл

2. Судалгааны ажлын дүн

Эдийн засгийн ерөнхий төлөв


Энэ удаагийн санал асуулгаар эдийн засгийн байдал сайжирч байна гэсэн хариулт нийт 6 удаагийн судалгааны хамгийн доод цэгт (12.1 хувь), муудсан гэсэн хариулт дээд цэгтээ (45.3 хувь) хүрсэн нь эдийн засгийн хямрал иргэдийн амьдралд бодитойгоор нөлөөлж буйг харууллаа.

Зураг 1. Монгол улсын өнөөгийн эдийн засгийн байдал таны бодлоор



Эдийн засгийг сэргээхийн тулд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих (51 хувь), зээлийн хүүг бууруулах (34.9 хувь) хэрэгтэй гэж иргэдийн ихэнх нь хариулсны зэрэгцээ уул уурхай (57.4 хувь), ХАА (33.9 хувь), боловсруулах үйлдвэрлэл (27.1 хувь) зэрэг салбарууд нь эдийн засгийн гол тулгуур болно гэж үзжээ.

Зураг 2. Таны бодлоор эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?




Өргөн хэрэглээний барааны үнийн талаар асуухад 82.7 хувь нь үнэ өсч байна гэж хариулсан нь өмнөх жилүүдийн түвшинд байгаа бөгөөд энэ нь 2007 оны 8 сараас эхлэн инфляци эргээд 2 оронтой тоонд шилжиж цаашид өсч иргэдийн дунд хүлээлтийг бий болгосонтой холбоотой байна.

Нийгмийн тулгамдсан асуудлууд


Өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн гэсэн иргэдийн хувь энэ онд хамгийн бага (13.3 хувь), доошилсон гэсэн нь хамгийн их (34.2 хувь) байлаа.

Зураг 3. Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд сайжирсан уу?




Санал асуулгад оролцсон иргэдийн 60 орчим хувь нь хүн амын ядуурал нэмэгдэж байна, 73.3 хувь нь ажилгүйдэл өссөн гэж хариулсан нь өндөр хэвээр байна. Харин ҮСГ-ын мэдээгээр Монгол улсын нэг өрхийн сарын дундаж орлого 2008 онд өмнөх оноос 37.9 хувийн өсөлттэй, зарлага нь 25.6 хувь өссөн байгаагаас үзэхэд хүн амын амьжиргааны түвшин дээшилсэн гэж хэлэх үндэслэлтэй байгаа хэдий ч иргэдийн бодит орлого төдийлөн дээшлээгүй байна. Иймээс дээрх тоо баримт нь хүн амын иргэдийн орлогын өсөлт тэнцвэргүй байгааг өгүүлж байж болох юм. Өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлт нь цөөхөн хүний орлогыг хэт өсгөж, дийлэнх хүний амьдралд нөлөөлөхгүй байна гэсэн өнгөрсөн онуудын дүгнэлтэд хүргэж байна.

Зураг 4. Таны бодлоор хүн амын ядуурлын түвшин буурсан уу?



ҮСХ-оос гаргадаг статистикийн мэдээллээс харахад хөдөлмөр эрхлэлтийн албанд албан ёсоор бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоогоор тооцсон ажилгүйдлийн түвшин 2005, 2006, 2007, 2008 онуудад харгалзан 3.3, 3.2, 2.8, 2.8 хувь байв. Харин ҮСХ-оос явуулдаг санал асуулга судалгааны дүнгээс харахад ажилгүйдлийн түвшин 2002-2003 онд 14.2 хувь, 2006-2007 онд 11.3 хувь байсан бол 2007-2008 онд бага зэрэг буурч 9.2 хувь болсон байна. Хэдий 2002, 2003 оноос хойш ажилгүйдэл ийнхүү буурч байгаа ч санал асуулгын дүнгийн өссөн гэсэн хариулт давамгайлж буй нь ажлын насны хүн амд харьцах ажиллах хүчний оролцоо буурч буйтай холбоотой байж болох юм.


Зураг 5. Ажилгүйдлийн тоо таны бодлоор



Санхүү эдийн засгийн хямрал


Дэлхийн санхүү эдийн засгийн хямрал Монгол улсын эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа талаар асуухад иргэдийн 50 орчим хувь нь үнэ өссөн, 40 орчим хувь нь ажилгүйдэл нэмэгдсэн, 32.8 хувь нь ядуурал нэмэгдсэн гэсэн бол өөрийн өрхийн талаар хариулахдаа иргэдийн 80 гаруй хувь нь өрхийн орлогын байдал муудсан гэж хариулжээ. Өрх гэрүүд тансаг хэрэглээ, томоохон худалдан авалт хийхээ багасгаж (68 хувь), мөнгөн хуримтлал хийж (17.4 хувь), үл хөдлөх хөрөнгөө зарах (9.9 хувь) замаар хямралыг даван туулж байна гэжээ.

Зураг 6. Дэлхийн санхүү эдийн засгийн хямрал танай өрх гэрт хэрхэн нөлөөлж байна вэ?



Дийлэнх иргэд (57.5 хувь) Оюу толгой, Таван толгойн ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах нь Монгол улсыг эдийн засгийн хямралаас гаргана гэсэн нь ихэнх иргэд уул уурхайн салбар манай улсын эдийн засгийг хөгжүүлнэ гэж эхний хэсэгт хариулсантай нийцэж байна.

Зураг 7. Таны бодлоор Монгол улс эдийн засгийн хямралаас хэрхэн гарах боломжтой вэ?




Харин үүний хажуугаар жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, банк санхүүгийн салбарыг тогтворжуулах, барилгын салбарыг зогсонги байдлаас гаргахад дэмжлэг үзүүлэх зэрэг нь мөн тулгамдсан асуудлууд болж байна.

Татварын талаар

Иргэдийн 54.8 хувь нь татварын түвшин өндөр байна, 60.9 хувь татвараас зайлсхийх явдал нийтлэг байдаг гэж хариулсан нь өндөр хувийн жин эзэлж байгаа хэдий ч өмнөх онуудаас 10-20 нэгж хувиар буурсан нь 2006 онд татварын багц хуулинд өөрчлөлт оруулж 2007 оны 1 сарын 1-ээс мөрдөж эхэлсэнтэй холбоотой байна.

Зураг 8. Татварын ерөнхий түвшин таны бодлоор ямар түвшинд байна?




Таны бодлоор татварын ачаалал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн үү гэсэн асуултад 47.9 хувь нь нэмэгдсэн гэсэн нь 2006 оны судалгаанаас 15.2 нэгжээр буурч, 25.6 хувь нь хэвэндээ гэсэн нь 7.1 нэгжээр, 8.0 хувь нь буурсан гэсэн нь 4.4 нэгжээр тус тус нэмэгдсэн байна. Нийт 5 судалгааны дүнг үзэхэд татварын ачаалал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн гэсэн хариулт 2002 оноос хойш буурсаар 77.4 хувиас 47.9 хувьд хүрсэн бол, хэвэндээ болон буурсан гэсэн хариултууд бага зэрэг өсч тус тус 18.1 хувиас 25.6 хувьд, 3.1 хувиас 8.0 хувьд хүрчээ.

Банк санхүүгийн салбар

Иргэдийн олонх нь одоо үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог боломжийн гэж үзэж байна. Банкны үйл ажиллагаа эргэлзээтэй гэж 52.6 хувь, банкинд итгэх итгэл буурсан гэж 22.9 хувь нь хариулсан нь хамгийн дээд цэгтээ хүрчээ. Анод, Зоос банкууд төлбөрийн чадвараа алдаж дампуурсан нь банк санхүүгийн салбарын үйл ажиллагаанд эргэлзэх байдлыг нэмэгдүүлж, итгэх итгэлийг бууруулсан байна. 1996, 1998-1999 онуудын банкны хямралын дараагаар иргэдийн банкинд итгэх итгэл сэргэтэл нэлээд удаан хугацаа өнгөрсөн буюу 2002 оноос хойш бага багаар нэмэгдэж эхэлсэн нь банкны системд итгэх итгэлийг олоход нэлээд хугацаа, багагүй хөдөлмөр шаардагддаг болохыг харуулсан.

Зураг 9. Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй банкуудын тоо таны бодлоор




Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ хүнд сурталтай, чирэгдэлтэй байна гэсэн хариулт энэ жил хамгийн дээд цэгтээ (37.5 хувь) хүрч, хувь хүнд хүрч, хэвийн үйлчилж байна гэсэн хариулт нэлээд буурч (48.5 хувь) хамгийн бага болох 2002 оны дүнтэй дөхөж очжээ.

Зураг 10. Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ




Иргэдийн дийлэнх нь (62.2 хувь) мөнгөний хэрэгцээ гарвал банкинд хандана гэсэн хэвээр байна. Энэ нь банкууд банк бус санхүүгийн байгууллагууд болон ломбард, хувь хүнээс илүү найдвартай, хүү багатай зээлдэгч болохыг илтгэхийн зэрэгцээ банкуудын зээлийн үйлчилгээний төрөл нэмэгдэж иргэдэд илүү хүрэлцээтэй болсон, иргэд ч банкны зээлийн талаар илүү сайн ойлголттой болж буйтай холбоотой.

Зураг 11. Мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ?




Иргэдээс банкнаас бусад санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг эсэх талаар асуухад санал асуулгад оролцогсдын 38.9 хувь нь тийм гэсэн өмнөх судалгааны дүнгээс нэлээд өсчээ. Энэ нь банк бус санхүүгийн байгууллагуудын хяналт шалгалтын системийг сайжруулсан буюу үүнийг төвлөрүүлэн гүйцэтгэх Санхүүгийн зохицуулах хороо шинээр байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрч буйтай нэг талаас холбоотой. Мөнгөний хэрэгцээ гарвал иргэдийн багахан хувь нь банк бус санхүүгийн байгууллагад хандана гэж хариулсныг санавал банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээнээс бусад үйлчилгээг иргэд илүүтэйгээр хэрэглэж байж болох юм.

Зураг 12. Та банк бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг үү?




Гадаадын санхүүгийн байгууллагуудыг оруулж ирэх нь ач холбогдолтой гэж 32.6 хувь хариулсан нь хамгийн доод түвшиндөө хүрчээ.

Зураг 13. Гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь хэр ач холбогдолтой вэ?



Өмнөх жилүүдэд хийсэн судалгаануудын дүнгээс үзвэл карт хэрэглэгчдийн тоо жилээс жилд өсч, өнөөгийн байдлаар судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү хувь нь (56.5 хувь) карт эзэмшдэг болсон байна.

Зураг 14. Та бэлэн бус тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү?




Санал асуулгын банк санхүүгийн салбарын талаарх энэ хэсгийг нэгтгэн дүгнэхэд дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үр нөлөөгөөр манай банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа доголдсон нь иргэдэд банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг найдвартай эсэхэд эргэлзээ төрүүлж, иргэдийн банкинд итгэх итгэл буурсан дүр зураг

харагдаж байна. Харин өмнөх жилүүдтэй харьцуулахад ББСБ-аар үйлчлүүлдэг иргэдийн тоо нэлээд нэмэгдэж, бэлэн бус тооцооны хэрэгсэл болох картыг өргөн хэрэглэдэг болсон байна.

Хадгаламж, хуримтлал


Зураг 15. Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ?



Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ гэсэн асуултанд давхардсан тоогоор санал асуулгад оролцсон иргэдийн 38.8 хувь нь банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, 7.2 хувь нь бусдад зээлдүүлдэг, 21.7 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 2.8 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 3.0 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 29.2 хувь нь бусад гэж хариулжээ. Үүнийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг гэсэн хариулт 1.2 нэгжээр буурч, банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг, бусдад зээлдүүлдэг, үнэт цаасанд байршуулдаг, хувьцаа худалдаж авдаг гэсэн хариултууд харгалзан 9.0, 1.6, 1.3 ба 1.4 нэгжээр өсчээ.

Хуримтлал бүхий иргэдийн дийлэнхи нь банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг эсвэл худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг байна. (Бусад гэсэн хариулт нэлээд хувийг эзэлж байгаа нь хуримтлалгүй иргэд энэ хариултыг сонгосон гэж үзлээ.) Өмнөх судалгаануудын дүнтэй харьцуулахад банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг иргэд жилээс жилд өсч энэ онд хамгийн дээд цэгтээ хүрсэн нь хадгаламжийн хэмжээ нэмэгдсэнийг харуулж байна. (Шигтгээ, Зураг 12) Иргэдийн багахан хувь нь үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг нь манай улсын үнэт цаасны зах зээлийн хөгжил сул байгаатай холбоотой юм.


Зураг 16. Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ?



Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ гэсэн асуултанд иргэдийн 62.6 хувь нь бэлэн мөнгөөр, 17.6 хувь нь бэлэн бус мөнгөний хэлбэрээр, 5.8 хувь нь үнэт цаасаар, 5.9 хувьцаагаар, 9.4 хувь нь бусад гэж хариулжээ. Өмнөх судалгаа буюу 2006 оны дүнтэй харьцуулахад бэлэн мөнгөөр гэсэн хариулт 2.2 нэгжээр буурч, бэлэн бус мөнгө, үнэт цаас, хувьцаа гэсэн хариултууд тус тус 2.6, 2.0 ба 1.9 нэгжээр өссөн байна.


Судалгааны дүнгээс харахад мөнгөө бэлэн мөнгөний хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг иргэд нийт санал асуулгад оролцогчдын дийлэнхи нь байгаа ч тус хариулт жилээс жилд багасаж байгаа нь иргэд бэлэн бус хэлбэрээр мөнгөө байршуулах сонирхолтой болж байгааг илэрхийлж байна.

Зураг 17. Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ?



Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ гэсэн асуулгад 79.1 хувь нь төгрөгөөр, 8.3 хувь нь америк доллараар, 7.0 хувь нь бусад гэж хариулсан нь 2007 оны дүнгээс харгалзан 3.2, 3.1 ба 3.9 нэгжээр өссөн байна. 2002 онд иргэдийн 38.5 хувь нь ам. доллараар хуримтлалаа хийдэг гэсэн бол 2003-2009 онд ам. доллараар хуримтлалаа хийдэг иргэдийн тоо 5.2-8.3 хувийн хооронд хэлбэлзэж байна.

Зураг 18. Хадгаламжийн хүү таны бодлоор




Өнөөгийн хадгаламжийн хүүг санал асуулгад оролцсон иргэдийн 56.2 хувь нь бага байна, 28.1 хувь нь боломжийн гэж үзэж байгаа нь 2007 оны дүнгээс тус тус 4.2 ба 0.8 нэгжээр өсчээ. Харин 12.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь 2.1 нэгжээр буурсан байна. 2003 оноос хойш 6 жилийн байдлаар хадгаламжийн хүүг бага гэж үзэж буй иргэдийн хувь бараг өөрчлөгдөөгүй

бөгөөд дунджаар 54.8 хувь, боломжийн гэж үзэж буй иргэдийн жин дунджаар 28.3 хувьтай мөн өөрчлөлт багатай байна.

Иргэдийн хадгаламж, хуримтлалын талаарх санал асуулгын дүнгээс харахад өмнөх судалгаа хийсэн жилүүдтэй харьцуулахад хадгаламж, хуримтлалаа худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг иргэдийн тоо багасч, банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг иргэдийн тоо нэлээд өссөн боловч иргэдийн дийлэнхи нь хадгаламжийн хүүг бага гэж үзэж байна. Судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү хувь нь хуримтлалаа бэлэн мөнгөөр байршуулахыг илүүд үздэг бөгөөд төгрөгөөр хадгалдаг байна. Гэсэн хэдий ч өмнөх судалгаануудын дүнтэй харьцуулахад бэлэн мөнгөөр байршуулахыг илүүд үздэг иргэдийн тоо жилээс жилд буурч байгаа хандлага ажиглагдаж байна.

Зээл


Зураг 19. Танд зээлийн хэрэгцээ байдаг уу?



Зээлийн хэрэгцээ танд байдаг уу гэсэн асуултанд 84.3 хувь нь тийм, 11.3 хувь нь үгүй гэж хариулсныг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад тийм гэсэн хариулт 2.6 нэгжээр өсч, үгүй гэсэн хариулт 2.7 нэгжээр буурсан байна.

Судалгаа явагдсан онуудын дүнгээс харахад зээлийн хэрэгцээ байдаг гэж хариулсан иргэдийн хувь тогтмол 80 хувиас илүү байгаа нь иргэдэд зээлийн хэрэгцээ маш өндөр хэвээр байгааг илтгэж байна. Ялангуяа энэ жилийн хувьд зээлийн хэрэгцээ байна гэж хариулсан иргэдийн тоо дээд цэгтээ хүрчээ.


Зураг 20. Танд банк санхүүгийн байгууллагуудаас олгож буй зээл хүртээмжтэй байдаг уу?



Банк санхүүгийн байгууллагаас олгож буй зээл хүртээмжтэй байдаг эсэх талаар асуухад иргэдийн 29.9 хувь нь тийм, 51.8 хувь нь үгүй, 14.5 хувь нь мэдэхгүй гэжээ. Үүнийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад тийм гэсэн хариулт 11.5 нэгжээр буурч, үгүй гэсэн нь 13.1

нэгжээр өссөн байна. Зээл хүртээмжтэй байдаг гэсэн хариулт 2005-2007 онуудад хамгийн өндөр буюу 40-41 гаруй хувийн хооронд хэлбэлзэж байсан хэдий ч энэ нь зээлийн эрэлт хэрэгцээ бүхий иргэдийн тоотой харьцуулахад хоёр дахин бага байгаа юм.


Зураг 21. (Асуулт 6.3) Таны бодлоор банк санхүүгийн байгууллагуудаас зээл авахад



Судалгаанд оролцсон иргэдийн 23.5 хувь нь банк санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй, 55.5 хувь нь хүндрэлтэй байдаг гэж үзсэн бол 10.5 хувь нь мэдэхгүй хариулжээ. Үүнийг өмнөх (2007 он) судалгааны дүнтэй харьцуулахад хүндрэлгүй гэсэн хариулт 14.3 нэгжээр буурч, хүндрэлтэй гэсэн нь 9.3 нэгжээр өссөн байв. Санал асуулга явуулсан нийт 6 удаагийн судалгаатай харьцуулахад зээл авахад хүндрэлгүй гэсэн хариулт энэ жил нэлээд буурч 2002 оны түвшинтэй дөхөж очсон бол эсрэгээр, хүндрэлтэй гэсэн хариулт өсч хамгийн их түвшин болох 2002 оны түвшинд дөхжээ.

Зээлийн барьцаа хөрөнгө, хүү, эргэн төлөх хугацаа, бичиг баримт бүрдүүлэлт, түүнчлэн зээлээ төлөх эх үүсвэр буюу байнгын орлого зэрэг нөхцөлүүдээс хамаарч иргэд зээл авахад бэрхшээлүүд учирдаг бөгөөд иргэдийн хариултаас харахад зээлийн эдгээр нөхцөлүүд хатуу байгаа нь харагдаж байна.

Зураг 22. Таны бодлоор зээлийн хүү



Иргэдийн 69.6 хувь нь зээлийн хүү өндөр гэж үзэж байгаа нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 4.6 нэгжээр өссөн бол 14.8 хувь нь боломжийн 8.6 хувь нь мэдэхгүй гэсэн нь тус тус 7.8 ба 1.3 нэгжээр буурсан байна. Судалгаа хийсэн жилүүдээс харахад зээлийн хүү өндөр байна гэж үзэж буй иргэдийн хувь 2002 оноос хойш тогтмол өссөн буюу 2002 онд зээлийн хүү өндөр байна гэсэн иргэдийн хувь ойролцоогоор 50 хувь байсан бол 2009 онд 70 хувь болж нийт 20 нэгжээр өсчээ.

Зээлийн хүү 2004 оноос хойш буурсаар ирсэн боловч ерөнхий түвшин өндөр байгаа учраас иргэд ийнхүү хүү өндөр байна гэж хариулсан хэвээр байна. Харин банкууд иргэдийн зээлийн эрсдэлийг өндөр байна гэж үздэг, мөн үнэ ханшийн тогтворгүй байдал үүсэх магадлал өндөр байдгаас хүүгээ бууруулах боломжгүй байж болох юм.

Санал асуулгын зээлжилтийн талаархи энэ хэсгийн дүнгээс харахад санал асуулгад оролцсон иргэдийн 80-аас илүү хувьд нь зээлийн хэрэгцээ байдаг бол 50-аас илүү хувь нь зээлийн хүртээмж муу, зээл авахад хүндрэлтэй гэж үзжээ. Зээлийн хүү өндөр байна гэсэн иргэдийн тоо ч мөн өсч 70 орчим хувьд хүрчээ. Эндээс дүгнэвэл иргэдэд зээлийн хэрэгцээ маш их байдаг боловч зээл авах нөхцөл боломж муу, хүртээмжгүй байдаг нь харагдаж байна.


Бичил санхүү

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын хэмжээнд бичил санхүүгийн зах зээл хурдацтай хөгжиж байна. Бичил санхүүгийн үйл ажиллагаа нь иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинээр ажлын байр бий болгох замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, шинэ технологи, үйлдвэрлэл, бүтээгдэхүүн бий болгох, бичил болон том бизнесүүдийг холбож өгөх зэрэг олон талын ач холбогдолтой байдаг.

Манай улсад бичил санхүүгийн хөгжил эхэн үедээ Засгийн газар болон донор байгууллагуудаас хязгаарлагдмал хүрээнд хэрэгжүүлж ирсэн төсөл, арга хэмжээгээр хязгаарлагдаж байлаа. Бичил санхүүжилтийг тодорхой хугацаанд хэрэгжиж дуусах төсөл гэдэг утгаар хүлээн авч ханддаг байсан бөгөөд төслийн зорилго нь эргэн төлөгдөх нөхцлөөр маш бага хүүтэй, эсвэл хүүгүй зээл олгоход чиглэгдэж байв. Харин 1998 оноос хойш бичил санхүү нь ядуурлыг бууруулах, хөрөнгөтэй болох, орлогоо нэмэгдүүлэх хүчтэй арга хэрэгсэл болон хөгжиж эхэлсэн байна. Бичил санхүүгийн салбар нь манай улсын хувьд харьцангуй шинэ салбар бөгөөд Монголбанкны нийгэм, эдийн засгийн санал асуулгад 2005 оноос хойш бичил санхүүгийн салбарын талаарх асуултуудыг багтаах болсон.

Энэ хэсэгт Монгол дахь бичил санхүүжилтийн өнөөгийн байдлын талаарх иргэдийн санал бодол, мэдлэгийг санал асуулгын дүнд үндэслэн тайлбарлахыг оролдлоо.


Зураг 23. Та бичил санхүүгийн талаар ойлголттой юу?



Бичил санхүүгийн талаар иргэдийн 60.4 хувь нь ойлголттой, 18.5 хувь нь ойлголтгүй гэсэн нь өмнөх судалгаа буюу 2006 оны дүнгээс тус тус 3.4 болон 18.5 нэгжээр буурсан байв. Харин 17.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Тус асуултыг асуусан 3 удаагийн судалгааны дүнг үзэхэд 2005 оноос хойш бичил санхүүгийн тухай ойлголттой гэсэн иргэдийн тоо бага зэрэг буурч, ойлголтгүй гэсэн нь нэмэгджээ.

Бичил санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд олон нийтийн бичил санхүүгийн болвсролын түвшин ямар байгаагаас ихээхэн хамааралтай. Харин манай орны хувьд энэ салбар нь харьцангуй шинэ салбар бөгөөд үйлчилгээнийх нь цар хүрээ хумигдмал, зохицуулж буй эрх


Зураг 26. Хэрэв бичил зээл авч ашигладаг бол ямар үйл ажиллагаа (бизнес) эрхэлдэг вэ?



Хэрэв бичил зээл авч ашигладаг бол түүгээрээ ямар үйл ажиллагаа санхүүжүүлдэг вэ гэсэн асуултад давхардсан тоогоор 7.8 хувь нь газар тариалан, 9.3 хувь нь хүнсний ногоо, 8.6 хувь нь мал аж ахуй, 14.5 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл, 1.4 хувь нь зочид буудал, 6.8 хувь нь бусад үйлчилгээний төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн нь 2007 оны судалгааны дүнгээс харгалзан 2.1, 3.3, 1.5, 5.9, 0.3 болон 0.3 нэгжээр өссөн бол хамгийн их буюу 22.4 хувь нь худалдаа наймаа, 2.6 хувь нь аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн нь тус тус 3.9, 0.1 нэгжээр буурчээ. Иргэдийн 22.2 хувь нь бусад хэмээх хариултыг сонгосон.

Иргэдийн 60 хувь л бичил зээлийн талаар ойлголттой гэж хариулсныг дээрх асуулттай харьцуулж үзвэл бичил зээл авч ашигладаг зарим иргэд нэгээс дээш төрлийн аж ахуй эрхэлдэг болох нь харагдаж байна. Тус асуултыг тавьсан 4 удаагийн судалгааны дүнгээс үзвэл бичил зээлийг хамгийн их ашигладаг салбар нь худалдаа наймаа байгаа хэвээр боловч 2005 оноос хойш тус салбарын жин 30.9 хувиас 22.4 хувь хүртэл буурсан. Үүний дараагаар жижиг дунд үйлдвэрлэл орж байгаа юм.


Зураг 27. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ?



Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ гэхэд санал асуулгад оролцогсдын 3.6 хувь нь 100000 төгрөгөөс доош, 5.7 хувь нь 100000-250000 төгрөг, 7.1 хувь нь 250000-500000 төгрөг, 13.3 хувь нь 500000-1 сая төгрөг гэсэн нь өмнөх судалгаа буюу 2006 оны дүнгээс харгалзан 0.4, 0.9, 5.3, 5.3 нэгжээр буурсан бол 13.8 хувь нь 1-1.5 сая, 47.6 хувь нь 1.5-2 сая гэсэн нь тус тус 0.7 болон 14.4 нэгжээр өссөн байна. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад 1.5 саяас 2 сая хүртэлх төгрөгийн зээл хэрэгтэй гэсэн хариулт жилээс жилд өссөн байгаа нь 2005 оноос хойш төгрөгийн ханш унасан, инфляци өссөнтэй нэг талаас холбоотой. 2 сая төгрөгөөс дээш дүнг хариултанд оруулаагүй учир түүнээс ч дээш эх үүсвэрийн хэрэгцээ байгааг үгүйсгэхгүй юм.

2008 оны эцсийн байдлаар БСХС-аар дамжин олгогдсон зээлийн хамгийн дээд хэмжээ нь 15.0 сая төгрөг, хамгийн доод хэмжээ нь 30.0 мянган төгрөг байсан бөгөөд дундаж зээлийн хэмжээ нь 1.0 сая төгрөг байсан байна. Харин судалгаанд оролцогчдын дийлэнх хэсэг нь 1.0 саяас доош төгрөгийн эх үүсвэр шаардлагатай гэсэн бол үлдсэн хэсэг нь 1.0-2.0 сая төгрөгийн эх үүсвэр шаардлагатай гэсэн байна.

Зураг 28. Бичил бизнесийн үйл ажиллагаа явуулахад банк санхүүгийн байгууллагын зүгээс танд ямар хүндрэл учруулж байна вэ?




Эцэст нь бичил зээл авахад ямар бэрхшээлүүд тулгардагийг асуулаа. Санал асуулгад оролцогчдын 49.2 хувь нь зээлийн хүү өндөр гэсэн нь өмнөх судалгаа буюу 2006 оны дүнгээс 6.4 нэгжээр буурч, 23.3 хувь нь зээлийн хэмжээ бага, 16.1 хувь нь зээл авах боломжгүй гэсэн нь тус тус 5.9 болон 3.3 нэгжээр өсч, харин 21.4 хувь нь зээлийн хугацаа хангалтгүй, 6.6 хувь нь бусад гэж хариулсан нь өмнөх судалгаанаас төдийлөн өөрчлөгдөөгүй байна. 2005 оны судалгааны дүнтэй харьцуулахад зээлийн хэмжээ бага, зээл авах боломжгүй, зээлийн хугацаа хангалтгүй гэсэн хариултууд нэлээд өсчээ. Бичил зээл авч ашиглахад учирдаг хамгийн том бэрхшээл нь зээлийн хүү өндөр явдал хэвээр байна.

Жижиг дунд үйлдвэрлэл


Монголбанкнаас ЖДҮ-г эрхэлдэг эсэх, эрхэлдэг бол санхүүжилтийг хаанаас авдаг болон юунд зарцуулдаг талаар зарим асуултуудыг үүний өмнөх буюу 2007 оны санал асуулгаар асууж байсан боловч энэ удаагийн асуултууд өөрчлөгдсөн тул өмнөх асуулгатай харьцуулсангүй. Харин 2007 оны асуулгын дүнг товч танилцуулахад, иргэдийн 23.3 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг бөгөөд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхдээ ихэнх тохиолдолд банк (48.2 хувь), хувийн хуримтлал (24.3 хувь), хувь хүнээс (16.2 хувь) санхүүжилтээ авдаг эсвэл авах хүсэлтэй гэж хариулжээ. Түүнчлэн ЖДҮ эрхэлдэг иргэдийн тал орчим хувь нь банкнаас зээл авч эргэлтийн хөрөнгөд зарцуулдаг болон эргэлтийн хөрөнгөнд зориулж зээл авах хүсэлтэй гэсэн болон 19.3 хувь нь үндсэн хөрөнгөд зориулна гэсэн байлаа.

Зураг 29. Хэрэв та ЖДҮ эрхлэх хүсэлтэй бол эх үүсвэрийг хаанаас олох вэ?




ЖДҮ эрхлэх санхүүжилтээ олох иргэдийн гол суваг (70.6 хувь) нь банкны зээл байгаа бөгөөд 13.9 хувь нь гэр бүл, найз нөхдөөсөө эх үүсвэр олдог гэжээ. Оролцогчдын 60 гаруй хувь нь ЖДҮ эрхлэхэд 2 саяас дээш төгрөгийн эх үүсвэр шаардлагатай гэж хариулсан. ЖДҮ зориулалтаар зээл авахад иргэдийн талаас илүү хувь нь хүү өндөр, хугацаа хангалтгүй байна гэжээ. ЖДҮ эрхлэхэд учирч буй хамгийн том бэрхшээл нь эх үүсвэр байхгүй, зээл олдохгүй байна гэснээс харахад санхүүжилт хамгийн том бэрхшээл болж байна.

Зураг 30. Хэдий хэр хэмжээний эх үүсвэр шаардлагатай вэ?




Зураг 31. ЖДҮ эрхлэх зориулалтаар авах зээлийн хүү




ЖДҮ эрхлэх зориулалтаар авах зээлийн хүүний талаарх асуултад иргэдийн олонхи буюу 60.6 хувь нь хүү өндөр гэсэн бол 18.1 хувь нь боломжийн, 4.4 хувь нь хүү бага, 13.2 хувь нь мэдэхгүй гэжээ.

Зураг 32. ЖДҮ эрхлэх зориулалтаар авсан зээлийн хугацаа хангалттай эсэх



ЖДҮ эрхлэх зориулалтаар зээл авахад зээлийн хугацаа хангалттай эсэх талаар асуухад иргэдийн 54.4 хувь нь хангалтгүй хугацаатай байдаг, 18.8 хувь нь хангалттай, 19.9 хувь нь мэдэхгүй гэжээ.


Зураг 33. ЖДҮ эрхлэх зориулалтаар зээл авахад учирч буй хүндрэлүүд



ЖДҮ эрхлэх зориулалтаар зээл авахад учирч буй хүндрэлүүдийн талаар сонирхвол давхардсан тоогоор иргэдийн 24.1 хувь нь зээлийн гэрээ хатуу, 36.6 хувь нь барьцаа хөрөнгө байхгүй, 17.6 хувь нь бичиг баримт бүрдүүлэлт хүндрэлтэй, 30.3 хувь нь зээлийн хүү өндөр, 14.2 хувь нь зээлийг хугацаанд нь эргүүлж төлөхөд хүндрэлтэй, 5.9 хувь нь бусад хүндрэлүүд гардаг гэжээ.

Томоохон аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад ЖДҮ эрхлэгчдэд илүүтэйгээр нөлөөлдөг хэд хэдэн бэрхшээл бий. Тухайлбал жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн зах зээлийн хүртээмж бага байдаг бөгөөд зам тээвэр, цахилгаан эрчим хүч болон бусад дэд бүтэц муу байх нь тэдэнд хүндээр тусдаг. Түүнчлэн лиценз, тусгай зөвшөөрөл гэх мэт бизнест хүндрэл учруулдаг дүрэм, журмууд нь ЖДҮ эрхлэгчдэд илүүтэйгээр хүндрэл учруулж, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд саад болдог байна.

Зураг 34. Засгийн газраас ЖДҮ эрхлэхэд ямар дэмжлэг шаардлагатай вэ?



Эцэст нь ЖДҮ эрхлэхийг дэмжих үүднээс засгийн газраас ямар дэмжлэг шаардлагатай талаар асуухад иргэдийн дийлэнхи буюу 60.4 хувь нь хөнгөлөлттэй зээл олгох, 31.8 хувь нь үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, 24.5 хувь нь татварыг хөнгөлөх, 17.1 хувь нь ЖДҮ эрхлэгчдэд урамшуулал олгох гэжээ.

Засгийн газраас 2009 онд ЖДҮ-ийг дэмжих зорилгоор 50.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ЖДҮ эрхлэгчдэд олгохоор төсөвлөсөн боловч санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан 30.0 тэрбум төгрөгийг олгохоор болсон билээ. Энэхүү Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эхний ээлж нь арилжааны банкууд (Худалдаа хөгжлийн банк, ХААН банк, Хас банк) – аар дамжин олгогдож эхлээд байна.

Дүгнэлт

- Санал асуулгын дүнгээс харахад иргэдийн ихэнх нь Монгол улсын эдийн засаг муудсан гэж үзсэн бөгөөд эдийн засгийг хөгжүүлэхийн тулд томоохон уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэх, ЖДҮ-ийг хөгжүүлэх хэрэгтэй гэж үзсэн байна. Үүний тулд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг явуулж, зээлийн хүүг багасгаж, хугацааг нь уртасгах шаардлагатай гэж үзжээ. Иргэдийн дийлэнх нь өргөн хэрэглээний барааны үнэ өссөн гэж үзсэн хэвээр байна. Иргэдийн ихэнх нь урьдын адил газар хувьчлалыг дэмжиж байгаа хэвээр байна.
- Иргэдийн хариултаас харахад өрхийн амьжиргааны түвшин доогуур байгаа нь харагдаж байгаа бөгөөд үнийн өсөлтөөс шалтгаалан бодит орлого буурсантай холбоотой. Мөн ядуурлын түвшин урьдын адил өндөр байгаагийн зэрэгцээ, ажилгүйдлийн түвшин өссөн гэж хариулсан байна.
- Хямралаас шалтгаалан эдийн засгийн өсөлт буурч, үнэ өсч ажилгүйдэл нэмэгдсэн гэж иргэдийн ихэнх нь хариулжээ. Мөн хямралаас гарахын тулд иргэд тансаг хэрэглээгээ зогсоож, томоохон хэмжээний худалдан авалтаа багасгаж, мөнгөн хуримтлал хийж эхэлсэн нь санал асуулгаас харагдаж байна.
- Татварын ерөнхий түвшин өндөр байгаа гэж хариулсан иргэдийн тоо өссөн хэдий ч татварын багц хуулинд өөрчлөлт орсноор татварын ачаалал буурсан юм.
- Банк санхүүгийн системд доголдол гарч хэд хэдэн банкууд үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болж дампуурлын ирмэгт тулж иргэдийн банкинд итгэх итгэл буурч банкны үйл ажиллагаанд эргэлзэж эхлэсэн. Мөн банкны салбарын гол үйл ажиллагаа болох зээл олголт зогсонги байдалд орсон тул иргэд банкны үйл ажиллагаанд таагүй хандах байдал ихэссэн. ББСБ-ын хөгжил сул байгаа учир иргэд мөнгөний хэрэгцээ гарвал банкинд хандана гэсэн хариулт их хэвээр байна. Картын хэрэглэгчдийн тоо өссөн байна.
- Банкинд мөнгөө хадгалуулах иргэдийн тоо өссөн бөгөөд тэдний ихэнх нь мөнгөө төгрөгөөр байршуулсан байна. Зээлийн эрэлт урьдын адил өндөр байгаа хэвээр байгаа хэдий ч зээлийн олдоц бага, хүү өндөр, хугацаа богино гэж үзсэн хэвээр байна.
- Бичил санхүүгийн салбар эх үүсвэрийн дутагдалд орж зогсонги байдалд орсон нь иргэдийн хариултаас харагдаж байна. Бичил бизнес эрхлэгчдийн ихэнх нь худалдаа наймаа хийх, газарт тариалан эрхлэх, хүнсний ногоо тариалах, ЖДҮ эрхлэх сонирхолтой байдаг байна. Бичил санхүү эрхлэх зориулалтаар зээл авахад учирч буй гол бэрхшээл нь зээлийн олдоц муу, хүү өндөр, барьцаа хөрөнгө баталгаагүй, хугацаа хангалтгүй байдаг байна.
- ЖДҮ эрхлэгчдийн ихэнх нь банкнаас зээл авдаг бөгөөд тулгарч буй бэрхшээл нь мөн л олдоц муу, хүү өндөр, хугацаа хангалтгүй, хэмжээ бага, барцаа хөрөнгө баталгаагүй байдаг байна. Төр засгаас үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийн тулд бага хүүтэй, хөнгөлөлттэй зээл олгохыг хүсдэг байна.
- Иргэдийн ихэнх нь Монголбанкны бодлого үйл ажиллагааны талаар ойлголт муутай байдаг учир илүү дэлгэрэнгүй мэдээлэл хүсдэг бөгөөд хугацаанаасаа хожимдсон, үр дүн муутай арга хэмжээ авдаг гэж үздэг байна.